

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шивээговь сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2023/03/НА-СТА-ТТЗ

Цахим
хуудас:
www.audit.mn

Говьсүмбэр
аймаг

2023 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543179
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр
Цахим хаяг: baranbayarg@audit.gov.mn
Аудитор: С.Батцэцэг
Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govsumber@audit.gov.mn

ШИВЭЭГОВЬ СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
П.ГАНЧИМЭГ ТАНАА

2023.03.27 № 52

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Шивээговь сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Шивээговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,045.4 сая төгрөгийн зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой, иж бүрэн, эрх ба үүрэг байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал

008020197

гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар онцлох нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. ТЭЗ-тай байгуулсан жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 88 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,131.4	478.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,678.8	1,095.6
	Нийт хөрөнгийн дүн	4,810.2	1,573.6
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,774.5	1562.4
	Богино хугацаат өр төлбөр	35.7	11.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,810.2	1,573.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	4,990.8	2,110.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	5,125.4	2,304.5
	Үйл ажиллагааны үр дүн	-134.6	-193.7
	Үйл ажиллагааны бус үр дүн	0.0	-2,802.8
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-134.6	-2,996.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,909.1	1,772.9
	Тайлант оны үр дүн	-134.6	-2,996.8
	Эцсийн үлдэгдэл	4,774.5	1,562.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,264.1	2,052.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,947.7	1,381.7
	Үйл ажиллагааны ЦМГ	316.4	670.4
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	325.3	524.3
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.00	-0.6
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-8.9	145.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	168.1	159.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	159.2	304.8
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,885.2	1,700.4
	Урсгал зардал	2,885.2	1,195.1
	Хөрөнгийн зардал		505.3
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,885.2	1,700.4
	Улсын төсвийн санхүүжих	2,192.8	0.0
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	692.4	1,700.4

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шивээговь сумын Засаг даргын эрхэм зорилгоо “Манай байгууллага нь сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд оновчтой бодлого төлөвлөлт, бүтээмж, шинэчлэлд тулгуурласан, иргэнээ дээдэлсэн суралцагч хамт олон байна” гэж тодорхойлжээ.

Зорилтын хүрээнд ТЭЗ-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт 105 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 88%-тай дүгнэгджээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Ерөнхий Аудиторын орлогчийн 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2022-2023 онд аудитад баримтлах ерөнхий чиглэл”, МУЕА-ын 2022 оны А/89 дүгээр тушаал баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-т тусгасан асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг зөрчил илрээгүй болно.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тухайн байгууллагад онцлох асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

“Шивээговь сумын Засаг дарга” нь аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад зөрчил илрээгүй байна.

4.4.1.1 Харьяа байгууллагууд

Харьяа төсвийн байгууллагуудад Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад нийт 39.1 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Шивээговь сумын ЗДТГ нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр болох 24 тушаалын 39.1 сая төгрөгийг мэдээлээгүй

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.2 Харьяа байгууллагууд

Татварын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тулган баталгаажуулалтаар нийт 13.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Зарлагын гүйлгээг татварын цахим бүртгэлийн системээр шивэгдсэн эсэхийг тулгаагүйгээс Шивээговь сумын ЗДТГ-12.3 сая, Шивээговь сумын ИТХ-1.4 сая төгрөгийн зөрүү үүссэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

..Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй.....

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 281.8 сая төгрөгийн 9 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан бөгөөд энэ нь Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэдэг харьяа байгууллагуудын алдаа байна.

Аудитаар нийт 1,098.2 сая төгрөгийн 20 зөрчил илэрснээс, 4.5 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт, 416.2 сая төгрөгийн 9 зөрчилд албан шаардлага, 677.5 сая төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнээс 420.7 сая төгрөгийн зөрчил нь харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн байна.

Залруулагдаагүй нийт зөрчлийн 1,045.4 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлаас давсан тул “Өөрчлөлттэй” дүгнэлт өгсөн.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 677.5 сая төгрөгийн 7 зөрчил² илрүүлснээс 677.5 сая төгрөгийн 7 зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг хүргүүллээ.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн, нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 2 байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлттэй” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 702.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 281.8 сая төгрөгийн 9 алдааг аудитын явцад залруулж, 4.5 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 363.4 сая төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Шилэн дансны тухай хууль, бусад хууль тогтоомжийн нийцлийн аудитаар 52.8 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн байна. /Хавсралт 1-ээс үзнэ үү/

Өмнөх онтой харьцуулахад харьяа байгууллагуудын нийт зөрчлийн дүн 58.8% буюу 791.4 сая, төлбөрийн акт 39% буюу 1.3 сая, албан шаардлага 44% буюу 180.0 сая, зөвлөмж 376.0 сая төгрөг буюу 56.3%-аар тус тус нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд бүтцийн өөрчлөлтөөр ЕБС, СӨБ, соёлын төвүүд орон нутгийн төсвөөс улсын төсөвт шилжсэн боловч нэгтгэсэн санхүүгийн тайлан болон харьяа байгууллагуудын алдаа зөрчил буураагүй байна.

Аудитаар өгсөн албан шаардлагын 87.3% буюу 363.4 сая төгрөг нь санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил, 12.7% буюу 52.8 сая төгрөг нь Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил байна. /Хавсралт 1, 2-оос үзнэ үү/

5.2 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Төвлөрүүлэн захирагчид төлбөрийн акт, албан шаардлага хүргүүлээгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Татварын орлогын төлөвлөгөөг 281.2 сая төгрөгөөр биелүүлээгүй, хуулиар тогтоосон орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.1, 23.8.2, 23.8.14, 23.8.15, 23.8.16, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1 дэх заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь бүрэн биелүүлж ажиллах

1.2. Илрүүлэлт: АИТХ-ын тогтоолоор сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 459.4 сая төгрөгөөр баталснаас 175.0 сая төгрөгийг төвлөрүүлж, төвлөрүүлэх орлогыг 284.4 сая төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллах

1.3. Илрүүлэлт: Сумын татварын бус орлогыг төлөвлөхдөө бусад орлого гэсэн төрлөөр 64.0 сая төгрөгийг төлөвлөж баталсан боловч гүйцэтгэлээр 3.6 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэр заагдаагүй бусад орлогыг төлөвлөхгүй байх, орлогын бүрдүүлэлтийг судалгаанд үндэслэн төлөвлөж ажиллах

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тайлант оны эцэст сумын төсөвт байгууллагуудаас 91.2 сая төгрөгийг хэмнэлтээр буцаан төвлөрүүлсэн нь зардлын санхүүжилтийг орлоготой уялдуулан хуваарилаагүй, аймагт төвлөрүүлэх боломжтой орлогыг төвлөрүүлээгүй, тооцоолол судалгааг үндэслэлтэй тооцоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улирал бүр санхүүжилтийг олгохдоо харьяа байгууллагуудаас зардлын тооцоолол судалгаанд үндэслэн санхүүжилтийг олгож байх

2.2. Илрүүлэлт: 12 дугаар сард 3 дугаар сургуулийн зарцуулах эрхийг илүү нээснээс санхүүжилтийг 17,159.0 мянган төгрөгөөр илүү олгож, оны эцэст буцаан төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа байгууллагуудын санхүүжилтийг олгохдоо төсвийн хуваарийн дагуу олгоход анхаарч ажиллах

2.3. Илрүүлэлт: Нэгтгэлд хамрагдаж буй байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх талаар ажил хийгдээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2014 оны 326, 2019 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын 1

дүгээр зүйлийн 1.1.3, 1.1.10 дахь заалтуудыг зөрчсөн, эрх ба үүрэг байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналт сайжруулах, алдаа зөрчлийг бууруулах

3. Нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: 2022 оны санхүүгийн нэгтгэсэн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан ирүүлэхдээ хуульд заасан бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн нэгтгэсэн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуульд заасан бүрэлдэхүүн хэсгээр бэлтгэж ирүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл											
1	ТШЗ	9	281.8	9	281.8						
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	Дүн	9	281.8	9	281.8						
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	6	59.8			3	4.5	3	55.3		
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС	3	308.1					3	308.1		
4	ТТЗ	7	677.5							7	677.5
5	ТЕЗ										
	Дүн	16	1,045.4			3	4.5	6	363.4	7	677.5
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	4	52.8					3	52.8	1	-
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	4	52.8					3	52.8	1	-
	НИЙТ ДҮН	29	1,380.0	9	281.8	3	4.5	9	416.2	8	677.5